

Түрүүч нь өмнө нь нийтлэгдсэн

Хоёр: Эрдэм шинжилгээний хурал хийгээд оюун сэтгэхvйн ертөнцөд



Аугаа их ялалтын 70 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал Горно Алтай хот дахь АБНУ-ын Улсын их сургууль дээр 5 сарын 7-нд эхлэв.

Хуралдаанд Горний Алтайн Улсын их сургуулийн (ГАГУ) еронхий захирал, Бабин, мон /Г АУИС

/

-ийн дэд захирал, Оросын шинжлэх ухааны академийн Нийгмийн судалгааны хүрээлэнгийн Горно-Алтай дахь салбарын удирдлагын зовлолийн гишvүн Табаков Юрия Васильевич, АБНУ-ын сэтгvүлчдийн холбооны дарга Алушкин Борис Кондулеевич, “Вестник Горно-Алтайска” сонины еронхий редактор, АА АБНУ-ын сэтгvүлчдийн холбооны нэгдvүгээр орлогч дарга Алексей Сергеевич Ивашкин, Монгол улсын Үндэсний их сургуулийн профессор Наваанзоч Х.Цэдэв, Мон сургуулийн докторант багш, АБНУ-ын Улсын их сургуулийн аспирант Дашдоржийн Монхбат, Монгол улсын Орон нутгийн сэтгvүлчдийн “Шинэ эвлэл” холбооны удирдах зовлолийн дарга, “Ховдын толь” сонины еронхий редактор Гонгоржавын Тормонх

(

миний бие

)

“Мир Евразий” сэтгvүлийн еронхий редактор, тvүхийн шинжлэх ухааны доктор

профессор Модоров Николай Семенович, Тvvхийн ухааны доктор, профессор Чедурова Елизавета Михиаловна, ГАГУ-ын

(
Горно–Алтайский Государственный Университет
)

аспирант Владислев Терентьев, В.В. Бианкавын нэрэмжит Бийск хотын тvvхийн музейн захирал Грехова Елена Анатольевна, мон музейн эрдэм шинжилгээний ажилтан Стрелец Ольга Борисовна, Горно-Алтай хотын еронхий боловсролын нэгдвгээр сургуулийн тvvхийн багш Николаев Игорь Александрович, Хятад улсын Шинжааны их сургуулийн багш Ян Цзяо нарын эрдэмтэн судлаачид оролцож, тус тусын илтгэл хэлэлцүүлэв. Тvvнчилэн энэ эрдэм шинжилгээний хуралд

/
ГАГУ

/
Горний Алтайн Улсын их сургуульд эрдмийн зэрэг горилж буй Хятад улсын аспирантууд сонирхогч, ажиглагчаар оролцож, хэлэлцүүлсэн илтгэлүүдтэй холбоотой асуулт асууж, санал бодлоо илэрхийлж байсан юм.

Монгол улсын оролцогчдын хувьд профессор Наваанзоч Х.Цэдэв “Эх орны их дайнд Немцийн фашистуудыг бут ниргэхэд нийгмийн сэтгэлгээний хвчин зvйлүүд”, докторант Д.Монхбат

“Дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд Монгол улс ба Улаан армийн харилцаа”
Г.Тормонх

(
миний бие
)

“Халхын голын байлдаан ба дэлхийн хоёр дугаар дайнд оролцсон дайчдын мөрөөр” гэсэн илтгэлүүдийг орос хэл дээр илтгэж, хэлэлцүүлсэн юм.

Монголын оролцогчдын илтгэлийн хувьд Орос оронд байхгvй ховор баримтуудыг гаргаж ирсэн, вэл санааны хувьд залуу хойч вейг зов вэлээр толовшvлэхэд ихээхэн ач холбогдол бvхий сонирхолтой илтгэлүүд байна хэмээн оролцогчид саналаа хэлж, баяр хvргэж байсныг дурьдах нь зов байх. Тэрчлэн АБНУ-ын оролцогчид нэрт эрдэмтэд судлаачдын илтгэлүүд ч нэн ач холбогдолтой, цаашид тvvний мороор судалгаа шинжилгээ орнvлэх бодлого вйл ажиллагаандаа тусгаж авахад зайлшгvй шаардлагатай зvйлүүдийг хондож тавьж байсан юм.

Горний Алтайн Улсын их сургуулиас хуралдааны илтгэлүүдийг эрдэм шинжилгээний бичиг болгон хэвлvллнэ гэдгээ ч мэдэгдсэн.

Дүгнэлтийн хэлэлцүүлгийн үеэр энэхүү хурал нь зөвхөн нэг ялалтын 70 жил болсонтой холбогдож, зохиогдоод түүх болж үлдэхдээ биш харин сүүлийн үед хүн торолхтний оюун сэтгэхүйн ертөнцөд “гамшигт үзэгдэл” болоод буй хэт либералчилах, мон чанарыг орхигдуулж хэлбэрийг шүтэх, даган дууриах, ингэснээр хүн торолхтний хэзээ ч мартаж, гээж болохгүй заямал үнэт зүйлсийг үгүй хийж, сэтгэхүй нь боолчлогдмол болсон ард түмнийг хялбарханаар идэш болгон ашиглах гэсэн баруун товтэй /Америк!/ улс торийн бодлогын нолооллийг сааруулах учир холбогдлыг нь оргож, улмаа уламжлал болгон үргэлжлүүлэх нь зүйтэй гэсэн саналууд гарч байлаа. Хоёр орны сэтгүүлчдийн байгууллагаас оролцсон толоогч, судлаачдын хувьд энэ талаар оргон олон нийтэд чиглэгдсэн соён гэгээрүүлэх ажлуудыг боловсрол хийгээд эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд, эрдэмтэдтэй хамтран орнүүлэх нь зүйтэй гэсэн асуудал дээр санал нэгдсэн ба эрдэмтэд дуу нэгтэй дэмжиж байв.ÂÂ

Эрдэм шинжилгээний хурлын дараа бид А.В Анохины нэрэмжит Үндэсний музейд болсон “Ялалт ба зэвсэг” хэмээх дэлхийн дайнуудын үед хэрэглэгдсэн зэвсгийн түүхэн үзэсгэлэнгийн нээлтэд оролцож, АБНУ-ын Засгийн газрын нэгдүгээр орлогч сайд Ольги Александровн

а

Сафронов

а,

хотын дарга Виктор Облогин нартай уулзаж, дурсгалын зураг татуулав. Үзэсгэлэнгийн нээлтэн дээр орлогч сайд

Ольги Александровн

а

, хотын дарга, тэрчлэн үндэсний музейн захирал нар үг хэлж, түүхэн кино үзүүлэн, урлагийн тоглолт сонирхуулсан.

Музейн санал сэтгэгдлийн дэвтэр дээр бид сэтгэгдэл үлдээх болоход үндэсний худам Монгол бичгээрээ бичих нь зүйтэй гэсэн санал гарснаар бид энэ үүрэг надад оногдож, бид худам Монгол бичгээр болон орос хэл дээр сэтгэгдлээ бичиж монхолсон агаад үүнийг харж байсан Орос болон Алтайц нохдийн зарим нь Монголын эртний бичиг үсэг хэмээн ихэд олзуурхан гайхаж байсан.

Мон Монголын оролцогчдыг хотоос 20 орчим километрийн зайд Хадан гол /Катун голын эрэг дээр битүү хусан ой дотор орших агуу их сэтгэгч, зураач Николай Рерихийн хошоо үзүүлж, тэр хавийн буюу Хадан голын сав дагуух аялал жуулчлалын бүсийг сонирхуулав.

Оргон их Хадан морний эрэг дээр урт номрогоо номрон гvн алс руу ширтэж, бодлогшрох агуу зураач, сэтгэгчийн нvсэр том гантиг чулуун хошооний дэргэд хором тодий саатаж, голын урсгал ширтэн зогсоход ер бусын сэтгэгдэл тархийг эзэмдэнэ.

Â Ñ Үргэлжлэл бий....

Г.Төрмөнх

Â

ÂÂ Ñ

Â